



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СЭА-2026/095/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Пийк Ом Аудит” ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц.РЭНЦЭННОРОВ ТАНАА**

2026.02.25 № СЭА-2026/095/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус сургууль нь аймгийн Боловсролын газраас 24,512.1 мянган төгрөгийн ном сурах бичиг, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ОНӨГ-ын шийдвэрээр өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 252,269.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж орлогоор бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4</b>	<b>397,884,522.60</b>	<b>50,148,494.30</b>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		397,884,522.60	50,148,494.30
31211	Төрийн сангийн харилцах		397,884,522.60	50,148,494.30
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5</b>	<b>272,499.80</b>	<b>0.00</b>
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		272,499.80	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6</b>	<b>307,212,670.89</b>	<b>278,771,250.31</b>
35100	Түүхий эд материал		20,264,650.00	20,264,650.00
35110	Тусгай зориулалттай материал		20,264,650.00	20,264,650.00
35400	Хангамжийн материал		286,948,020.89	258,506,600.31
35410	Бичиг хэргийн материал		2,940,000.00	3,008,200.00
35420	Аж ахуйн материал		247,666,824.35	221,277,203.77
35470	Бусад хангамжийн материал		22,701,196.54	22,701,196.54
35600	Мал амьтад		13,640,000.00	11,520,000.00
<b>I</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>705,369,693.29</b>	<b>328,919,744.61</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>5,202,855,902.84</b>	<b>5,101,489,649.85</b>
392	Биет хөрөнгө		4,855,905,652.90	4,746,740,649.85
39201	Барилга, байгууламж, орон сууц		5,545,596,068.50	5,545,596,068.50
39202	Хуримтлагдсан элэгдэл		-1,269,133,607.80	-1,532,236,683.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл		21,090,500.00	21,090,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-21,090,500.00	-8,140,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		793,644,806.09	795,535,713.94
39206	Хуримтлагдсан элэгдэл		-424,819,648.63	-332,686,695.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		376,970,626.80	354,527,909.80
39208	Хуримтлагдсан элэгдэл		-196,664,180.20	-117,079,193.57
39217	Ном		30,311,588.14	20,133,529.38
393	Биет бус хөрөнгө		346,950,249.94	354,749,000.00
39301	Программ хангамж		15,085,000.00	7,925,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-14,958,750.06	0.00
39303	Бусад биет бус хөрөнгө		348,959,000.00	346,824,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		-2,135,000.00	0.00
<b>II</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>5,202,855,902.84</b>	<b>5,101,489,649.85</b>
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>5,908,225,596.13</b>	<b>5,430,409,394.46</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9</b>	<b>-</b>	<b>39,866,238.88</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>		<b>-</b>	<b>39,866,238.88</b>
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		-	39,866,238.88
<b>IV</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>-</b>	<b>39,866,238.88</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>5,908,225,596.13</b>	<b>5,390,543,155.58</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2,128,048,996.21	2,128,048,996.21
512	Хуримтлагдсан үр дүн		-64,162,297.01	-64,162,297.01
5122	Тайлант үеийн үр дүн			-517,682,440.55
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		3,844,338,896.93	3,844,338,896.93
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>5,908,225,596.13</b>	<b>5,390,543,155.58</b>

VI	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>5,908,225,596.13</b>	<b>5,430,409,394.46</b>
----	--	--	-------------------------	-------------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,028,382,839.50</b>	<b>4,237,481,982.63</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,622,382,900.00	3,756,118,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,622,382,900.00	3,756,118,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	405,999,939.50	481,363,682.63
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>285,433,607.16</b>	<b>405,679,630.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>285,433,607.16</b>	<b>405,679,630.98</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>73,061,916.07</b>	<b>99,607,689.00</b>
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,969,400.00	77,841,282.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,092,516.07	21,766,407.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	183,467,408.25	269,621,123.64
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	28,904,282.84	36,450,818.34
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,313,816,446.66</b>	<b>4,643,161,613.61</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,437,461,202.70</b>	<b>5,144,033,902.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,437,461,202.70</b>	<b>5,144,033,902.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,274,344,362.70</b>	<b>4,937,681,378.92</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,862,385,945.76</b>	<b>3,266,973,349.32</b>
210101	Үндсэн цалин	1,731,550,573.29	2,011,400,555.59
210102	Нэмэгдэл	915,511,448.52	1,026,094,743.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,162,313.95	93,900,000.00
210104	Урамшуулал	121,161,610.00	135,578,050.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>341,352,334.12</b>	<b>386,726,242.64</b>
210201	Тэтгэврийн даатгал	233,819,146.75	263,799,299.44
210202	Тэтгэмжийн даатгал	28,846,417.54	33,073,140.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,964,978.71	17,262,785.14
210204	Ажилгүйдлийн даатгал	12,837,227.47	14,507,981.09
210205	Эрүүл мэндийн даатгал	50,884,563.65	58,083,036.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>381,999,939.50</b>	<b>456,370,982.63</b>
210301	Гэрэл, цахилгаан	26,294,053.50	33,626,732.77
210302	Түлш, халаалт	223,848,930.00	302,260,743.86
210303	Цэвэр, бохир ус	131,856,956.00	120,483,506.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>82,777,820.00</b>	<b>117,035,260.00</b>
210502	Хоол, хүнс	82,777,820.00	117,035,260.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	<b>24,000,000.00</b>	<b>24,992,700.00</b>
210604	Урсгал засвар	24,000,000.00	24,992,700.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>40,223,497.23</b>	<b>70,513,032.02</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,259,900.00	4,583,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,963,597.23	65,929,132.02
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>519,744,826.09</b>	<b>548,636,373.39</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,153,941.24	88,261,275.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,910,200.00	21,839,040.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	384,680,684.85	438,536,058.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>163,116,840.00</b>	<b>206,352,524.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>163,116,840.00</b>	<b>206,352,524.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	145,913,440.00	206,352,524.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,203,400.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,437,461,202.70</b>	<b>5,144,033,902.92</b>
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-123,644,756.04	-500,872,289.31
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>451,465.30</b>	<b>16,810,151.24</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	14,690,151.24
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал	451,465.30	2,120,000.00
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-451,465.30</b>	<b>-16,810,151.24</b>
<b>V</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-124,096,221.34</b>	<b>-517,682,440.55</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>4,101,444,755.57</b>	<b>4,337,089,671.63</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>73,061,916.07</b>	<b>99,607,689.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	73,061,916.07	99,607,689.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,969,400.00	77,841,282.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,092,516.07	21,766,407.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,622,382,900.00</b>	<b>3,756,118,300.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,622,382,900.00	3,756,118,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	<b>405,999,939.50</b>	<b>481,363,682.63</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	405,999,939.50	481,363,682.63
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,049,262,500.41</b>	<b>4,602,586,866.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,889,796,810.41</b>	<b>4,396,234,342.93</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,889,796,810.41</b>	<b>4,396,234,342.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,861,284,955.57</b>	<b>3,211,409,965.78</b>
210101	Үндсэн цалин	1,731,823,073.09	1,950,820,240.21
210102	Нэмэгдэл	914,137,958.53	1,025,591,675.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,162,313.95	93,900,000.00
210104	Урамшуулал	121,161,610.00	141,098,050.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>342,725,824.11</b>	<b>402,150,887.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	232,629,504.78	273,506,271.50
210202	Тэтгэмжийн даатгал	28,446,629.06	32,177,279.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,771,581.72	16,088,439.50
210204	Ажилгүйдлийн даатгал	12,837,227.47	16,075,639.50
210205	Эрүүл мэндийн даатгал	54,040,881.08	64,303,258.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>381,999,939.50</b>	<b>456,370,982.63</b>
210301	Гэрэл, цахилгаан	26,294,053.50	33,626,732.77
210302	Түлш, халаалт	223,848,930.00	302,260,743.86
210303	Цэвэр, бохир ус	131,856,956.00	120,483,506.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>78,846,700.00</b>	<b>117,035,260.00</b>
210502	Хоол, хүнс	78,846,700.00	117,035,260.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,000,000.00</b>	<b>24,992,700.00</b>
210604	Урсгал засвар	24,000,000.00	24,992,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>69,684,497.23</b>	<b>70,513,032.02</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,259,900.00	4,583,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	63,424,597.23	65,929,132.02
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>131,254,894.00</b>	<b>113,761,515.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,344,694.00	91,922,475.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,910,200.00	21,839,040.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>159,465,690.00</b>	<b>206,352,524.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	159,465,690.00	206,352,524.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,262,290.00	206,352,524.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,203,400.00	
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>52,182,255.16</b>	<b>-265,497,195.30</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>65,662,900.00</b>	<b>82,238,833.00</b>
	Дотоод эх үүсвэрээр	65,662,900.00	82,238,833.00
222001	Тоног төхөөрөмж	65,662,900.00	82,238,833.00
223001	Бусад хөрөнгө		

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-65,662,900.00	-82,238,833.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-13,480,644.84	-347,736,028.30
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	411,365,167.44	397,884,522.60
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	397,884,522.60	50,148,494.30

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	-64,162,297.01	5,908,225,596.13
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			-517,682,440.55	-517,682,440.55
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	-581,844,737.56	5,390,543,155.58

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	4,753,896,182.63	3,849,867,845.44	904,028,337.19	89.14
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,179,921,100.00	3,756,118,300.00	423,802,800.00	99.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,790,415,500.00	3,756,118,300.00	34,297,200.00	99.10
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	389,505,600.00	-	389,505,600.00	0.00
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	481,363,682.63	481,363,682.63	0.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	481,363,682.63	481,363,682.63	0.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	92,611,400.00	99,607,689.00	(6,996,289.00)	107.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,771,400.00	77,841,282.00	1,930,118.00	97.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,840,000.00	21,766,407.00	(8,926,407.00)	169.52
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,753,896,182.63	4,337,089,671.63	416,806,511.00	91.44

21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,753,896,182.63	4,684,825,699.93	69,070,482.70	89.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,539,533,382.63	4,478,473,175.93	61,060,206.70	88.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,238,870,700.00</b>	<b>3,211,409,965.78</b>	<b>27,460,734.22</b>	<b>99.15</b>
210101	Үндсэн цалин	2,108,278,200.00	1,950,820,240.21	157,457,959.79	92.53
210102	Нэмэгдэл	1,028,998,300.00	1,025,591,675.57	3,406,624.43	99.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	93,900,000.00	(93,900,000.00)	100.00
210104	Урамшуулал	101,594,200.00	141,098,050.00	(39,503,850.00)	138.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>405,647,900.00</b>	<b>402,150,887.50</b>	<b>3,497,012.50</b>	<b>99.14</b>
210201	Тэтгэврийн даатгал	275,840,600.00	273,506,271.50	2,334,328.50	99.20
210202	Тэтгэмжийн даатгал	32,451,800.00	32,177,279.00	274,521.00	99.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,225,900.00	16,088,439.50	137,460.50	99.20
210204	Ажилгүйдлийн даатгал	16,225,900.00	16,075,639.50	150,260.50	99.10
210205	Эрүүл мэндийн даатгал	64,903,700.00	64,303,258.00	600,442.00	99.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>456,370,982.63</b>	<b>456,370,982.63</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	33,626,732.77	33,626,732.77	0.00	100.00
210302	Түлш, халаалт	302,260,743.86	302,260,743.86	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	120,483,506.00	120,483,506.00	0.00	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>126,799,300.00</b>	<b>117,035,260.00</b>	<b>9,764,040.00</b>	<b>95.12</b>
210502	Хоол, хүнс	126,799,300.00	117,035,260.00	9,764,040.00	95.12
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,992,700.00</b>	<b>24,992,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	24,992,700.00	24,992,700.00	0.00	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>71,982,100.00</b>	<b>70,513,032.02</b>	<b>1,469,067.98</b>	<b>83.01</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,583,900.00	4,583,900.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	67,398,200.00	65,929,132.02	1,469,067.98	81.25
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>214,869,700.00</b>	<b>196,000,348.00</b>	<b>18,869,352.00</b>	<b>91.22</b>
<b>210901</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	193,030,600.00	174,161,308.00	18,869,292.00	90.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,839,100.00	21,839,040.00	60.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>214,362,800.00</b>	<b>206,352,524.00</b>	<b>8,010,276.00</b>	<b>96.26</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	214,362,800.00	206,352,524.00	8,010,276.00	96.26
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	214,362,800.00	206,352,524.00	8,010,276.00	96.26
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		82,238,833.00	-82,238,833.00	
222	Дотоод эх үүсвэрээр		82,238,833.00	-82,238,833.00	
222001	Тоног төхөөрөмж		82,238,833.00	-82,238,833.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>4,753,896,182.63</b>	<b>4,684,825,699.93</b>	<b>69,070,482.70</b>	<b>98.50</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		397,884,522.60	-397,884,522.60	

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		50,148,494.30	-50,148,494.30	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	122	115	7	94.26
6	Удирдах ажилтан	4	4	0	100.00
7	Гүйцэтгэх ажилтан	118	111	7	94.07
8	Үйлчлэх ажилтан	0	0	0	0

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,197.7 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 9,510.3 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 6,687.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 9,510.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр орон тоонд батлагдаагүй байхад мужаан, жолоочийн ажлыг жижүүрүүдээр, хүний нөөцийн ажилтныг нягтлан бодогчоор хавсран гүйцэтгүүлэхээр томилж 9,510.3 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тоо, цалингийн сангийн хүрээнд үйл ажиллагаа явуулах албан шаардлага хүргүүлэв

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлант оны эхэнд төлөвлөгөөнд тусгаагүй гэх шалтгаанаар 6,687.4 мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлогын ангиллыг зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСННБОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандарт болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөвлөлтийг бодитой хийж орлогын ангиллыг зөв бүртгэх зөвлөмж хүргүүллээ.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйг ээр мужаан, жолооч хавсран ажиллуулж алдааг давтан гаргасан	1	9,510.3			1	9,510.3						
Тайлант оны эхэнд төлөвлөгөөнд тусгаагүй гэх шалтгаанаар орлогын ангиллыг зөрүүтэй бүртгэсэн.	1	6,687.4					1	6,687.4				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>16,197.7</b>			<b>1</b>	<b>9,510.3</b>	<b>1</b>	<b>6,687.4</b>				

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

